

ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ
УЛААНБААТАР ХОТЫГ 2020 ОН ХҮРТЭЛ ХӨГЖҮҮЛЭХ ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛАХ ТУХАЙ

2002 оны 2 дугаар сарын 26-ны өдөр Улаанбаатар хот

Дугаар 28

Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын 4 дүгээр зүйлийн 7 дахь хэсгийн 5 болон Хот байгуулалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2 дугаар заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь :

1. "Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө"-г хавсралтад заасан бүрдэлтэйгээр баталсугай.

2. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч М.Энхболдод даалгах нь:

а/ерөнхий төлөвлөгөөний үзэл баримтлалд тусгагдсан хотжилт эрчимтэй хөгжих, хотжилт эрчимтэй бус буюу аж ахуйг хязгаарлагдмал чиглэлтэй хөгжүүлэх, хөдөө аж ахуйг тэргүүлэх чиглэлтэй хөгжүүлэх бүс гэсэн хот байгуулалтын гурван бүсчлэлээр горимлож нийслэлийн нутаг дэвсгэрт хот байгуулалтын тасралтгүй үйл ажиллагааг явуулсугай;

б/чиг үүрэг, зориулалт, барилгажилтын өндөр, ландшафтын зохион байгуулалт гэсэн гурван ангиллаар Улаанбаатар хотын барилгажсан газар нутгийн судалгааны П үе шатны төсөл, газар ашиглалтын төлөвлөгөөг боловсруулж барилгажилтын орон зайн төлөвлөлтийг сайжруулах арга хэмжээ авч ажилласугай;

в/нийслэлийн алслагдсан дүүрэг, дагуул хот, тосгоныг эрчимтэй хөгжүүлэн хүн амын хэт төвлөрлийг үе шаттайгаар сааруулах чиглэл баримтлан ажилласугай.

3. Нийслэлийн хүн амын ундны усны эх үүсвэрийн нөөцийг нарийвчлан тогтоож хамгаалах, усан хангамжийн инженерийн барилга байгууламж барих бэлтгэл ажлыг эхлүүлэх, инженерийн дэд бүтэц, зам, тээврийн асуудлыг боловсронгуй болгох талаар арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Дэд бүтцийн сайд Б.Жигжид, Үйлдвэр, худалдааны сайд Ч.Ганзориг, Байгаль орчны сайд У.Барсболд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч М.Энхболд нарт тус тус даалгасугай.

4. Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд холбогдох норм, дүрмийг шинэчлэн боловсруулахыг Дэд бүтцийн сайд Б.Жигжид, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч М.Энхболд нарт үүрэг болгосугай.

5. Хот байгуулалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2 дахь заалтын дагуу Улаанбаатарын бүс нутгийн хөгжлийн төсөл, ерөнхий төлөвлөгөөний үе шатны төсөл боловсруулж, тэдгээрийн хэрэгжилтэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төвлөрсөн болон нийслэлийн төсөвт тусгах, гадаад, дотоодын байгууллага, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татан оролцуулах замаар санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч М.Энхболд нарт даалгасугай.

6. Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх, хот байгуулалт, барилгажилтын норм, дүрэм, журмыг салбарын бодлоготой уялдуулан боловсруулж мөрдүүлэхэд мэргэжлийн дэмжлэг үзүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд үүрэг болгосугай.

Монгол Улсын Ерөнхий сайд Н.ЭНХБАЯР

Дэд бүтцийн сайд Б.ЖИГЖИД

Хавсралтын дугаар: **Хавсралт1**

Хавсралтын нэр: **“УЛААНБААТАР ХОТЫГ 2020 ОН ХҮРТЭЛ ХӨГЖҮҮЛЭХ ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ”-НИЙ БҮРДЭЛ**

Хавсаргах файл:

Засгийн газрын 2002 оны 28 дугаар тогтоолын хавсралт

“УЛААНБААТАР ХОТЫГ 2020 ОН ХҮРТЭЛ ХӨГЖҮҮЛЭХ ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ”-НИЙ БҮРДЭЛ

1. ЗУРАГЛАЛЫН МАТЕРИАЛ:

А. Нийслэлийн хилийн цэс болон хот орчмын хөгжлийн хандлага.

АБ-1. Нийслэлийн ба хот орчмын бүсийн хот байгуулалтын хөгжлийн одоогийн байдал, хот орчмын экологи, хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ. М1: 100 000

АБ-2. Нийслэл хот орчмын бүсийн хот байгуулалтын хөгжлийн одоогийн байдал, нутаг дэвсгэрийн иж бүрэн үнэлгээ. М1: 100 000

АБ-3. Нийслэл хот орчмын бүсийн хүрээлэн буй орчин, байгаль хамгаалал. М1: 100 000

АБ- 4. Нийслэл хот орчмын бүсийн хөгжлийн тойм. М 1: 50 000

АБ- 5. Нийслэлийн хот байгуулалт, газар ашиглалтын хөгжлийн тойм. М1: 100 000

АБ- 6. Нийслэл хот байгуулалтын хөгжлийн чиг хандлага. М1: 100 000

АБ- 7. Нийслэлийн бүлэг суурингийн тогтолцоо, ангилал. М1: 100 000

АБ- 8. Хотын гадна тээврийн сүлжээ. М1: 100 000

АБ- 9. Нийслэлийн инженерийн дэд бүтэц, дулаан хангамж. М1: 100 000

АБ-10. Нийслэлийн инженерийн дэд бүтэц, цахилгаан хангамж. М1: 100 000

АБ-11. Нийслэлийн инженерийн дэд бүтэц, усан хангамж, ариутгах татуурга. М1: 100 000

АБ-12. Нийслэлийн инженерийн дэд бүтэц, холбоожуулалт. М1: 100 000

АБ-13. Нийслэлийн тусгай хамгаалалттай газар нутаг.

АБ-14. Нийслэлийн түүх, соёлын дурсгалын зүйлийн хадгалалт.

М1: 100 000

АБ-15. Нийслэл хот орчмын аялал жуулчлалын хөгжлийн төлөвлөлт. М1: 100 000

Б. Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөө.

В-1. Хотын хөгжлийн одоогийн байдал, хот орчмын экологи, хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ. М1: 100 000

В-2. Хотын хөгжлийн одоогийн байдал, хот орчмын экологи, хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ. М1: 100 000

В-2.1. Хүрээлэн байгаа байгаль орчны бохирдлын үнэлгээ. М1: 100 000

В-2.2. Газар нутгийн ашиглалтын байдал. М 1:25 000

В-2.3. Хүн амын орон сууцны хангамжийн түвшинд өгөх үнэлгээ. М 1: 25 000

В-2.4. Ландшафтын шинж байдалд өгөх үнэлгээ. М 1: 25 000

В-2.5. Улаанбаатар хотын барилгажсан газар нутгийн хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ. М 1: 25 000

В-2.6. Газар нутгийн үүрэг зориулалт, бүсчлэлийн төрөл. М 1: 25 000

В-3. Улаанбаатар хот /тойм/. М 1: 25 000

В-4. Улаанбаатар хот 2020 ерөнхий төлөвлөгөө. М 1: 5000

В-5. Дэвсгэр нутаг газар эдэлбэрийн хуваарилалт. М 1: 10 000

В-6. Хүрээлэн байгаа байгаль хамгаалал. М 1: 25 000

В-7. Хотын гудамж сүлжээ. М 1: 25 000

В-8. Зам тээврийн сүлжээ. М 1: 10 000

В-9. Цэцэрлэгжилт, ногоон байгууламж. М 1:10 000

В-10. Улаанбаатар хотын дулааны хангамж. М 1: 25 000

В- 11. Улаанбаатар хотын дулааны хангамж. М 1: 50 000

В-12. Улаанбаатар хотын цахилгаан хангамж. М 1: 25 000

В-13. Улаанбаатар хотын цахилгаан хангамж. М 1: 50 000

В-14. Улаанбаатар хотын усан хангамж. М 1: 25 000

В-15. Улаанбаатар хотын ариутгах татуурга. М 1: 25 000

В-16. Улаанбаатар хотын холбоожуулалт. М 1: 25 000

В-17. Улаанбаатар хотын инженерийн бэлтгэл арга хэмжээ. М 1: 25 000

В-18. Түүх, соёлын дурсгалт барилга, цогцолборын зэрэглэл байршил.

М 1: 25 000

В. Нийслэлийн бүс нутгийн үзэл баримтлал.

Тулгуур төв бүлэг суурингийн тогтолцоо /Улаанбаатар дэд бүс/. М 1: 500 000

Дэд бүтцийн хөгжлийн хандлага /Улаанбаатар дэд бүс/. М 1: 500 000
Ашигт малтмалын ордын мужлал. М 1: 500 000
ХАА-н хөгжлийн хандлага /Мал аж ахуй/. М 1: 500 000
ХАА-н хөгжлийн хандлага /Газар тариалан/. М 1: 500 000
Амралт, аялал жуулчлалын хөгжлийн төлөвлөлт. М 1: 500 000
Эрчим хүчний одоогийн байдал /1998 он/. М 1: 500 000
Хүн амын нутагшилт, хот суурингийн үүргийн ялгаа /1998 он/. М 1: 500 000
Нийслэл, нийслэлийн ногоон бүсийн нутаг дэвсгэр /1998 оны байдлаар/.
М 1: 100 000
10. Багануур, Багахангай дүүрэг. М 1: 100 000

2. БИЧИГЛЭЛИЙН МАТЕРИАЛ:

I боть. Улаанбаатар хотын хөгжлийн одоогийн байдал. 2000 он. /294 хуудас/
II боть. Улаанбаатар хотын барилгажсан газар нутгийн хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ. 2000 он. /419 хуудас/
III боть. Улаанбаатар хотын хөгжлийн хэтийн төлөв. /2000 он/ /359 хуудас/
IV боть. Нийслэлийн хилийн цэс болон хот орчмын бүсийн хөгжлийн хэтийн төлөв. 2000 он. / 209 хуудас/
V боть. Нийслэл хот орчмын бүсийн хөгжлийн үзэл баримтлал. 2000 он. /167 хуудас/
VI боть. Улаанбаатар хотын хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээ. 2001 он. /171 хуудас/

_____оОо_____